



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дундговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a>  Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Batsaikhant@audit.gov.mn">Batsaikhant@audit.gov.mn</a>  Ахлах аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn">Ugtakhbayarj@audit.gov.mn</a>  Аудитор: Мягмарсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Myagmarsurenby@audit.gov.mn">Myagmarsurenby@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>6</b>
3. Аудитын илрүүлэлт .....	8
<b>3.1 Албан шаардлага</b> .....	<b>8</b>
<b>3.2 Зөвлөмж</b> .....	<b>9</b>
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	<b>11</b>

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын орлон, 7-р баг, Сайнмагхан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цехны саар: dundgovi@audit.gov.mn

№ 006.03.27 № 94

төрийн \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газар нь 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 5.7 сая төгрөгийн үнэт цаасны тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй;
2. Хоршоо хөгжүүлэх сангаас төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллага нь 8.8 сая төгрөгийн үндсэн зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлэн, гэрээний үүргээ биелүүлээгүй;
3. Байгаль хамгаалах сан нь санхүүгийн тайлангаарх өглөгийн 7.7 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй;
4. Мал хамгаалах сан нь эвлэрлийн гэрээний хугацаанд иргэнээс авах 18.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй;
5. Нийт татварын орлогын батлагдсан төлөвлөгөөнөөс 862.2 сая төгрөгийн төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19 дахь заалт,

4826050316

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаал “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.11 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 дахь заалт, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74<sup>1</sup>.8 дахь заалт, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 33.1 дахин их, татварын орлого нийт дүнгээр тасарсан, санхүүгийн тайлан дахь өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, төсөл хэрэгжүүлэгч нь зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, үнэт цаасны тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулаагүй зэрэг нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой төсөвт байгууллагуудын цалингийн зардал өмнөх оноос 170.6 сая төгрөгөөр өссөн байна. Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 17 дугаар тогтоолоор тайлант онд 2,119.6 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,257.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 59.0 хувиар биелүүлж, 862.2 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### **Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлого бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний эрхийг хаасантай холбоотой төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардалтай холбоотой өр төлбөр өсч, өмнөх оноос 250.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 138 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 85.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль,

Acti  
Go to

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12 сарын 31
1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,463,897.8	1,466,903.8
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	972,792.1	1,002,906.7
1.1.3 АВЛАГА	166,772.7	161,304.8
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	131,586.7	131,146.0
1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	192,746.2	171,546.2
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,334,960.0	3,062,735.0
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,334,960.0	3,062,735.0
1.2.2.02 Биет хөрөнгө	2,313,344.6	3,042,783.4
1.2.2.03 Биет бус хөрөнгө	21,615.4	19,951.6
1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,798,857.7	4,529,638.8
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	53,091.6	303,474.2
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	53,091.6	303,474.2
2.1.1.03 Өглөг	53,091.6	303,474.2
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,745,766.1	4,226,164.7
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	3,745,766.1	4,226,164.7
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	452,108.8	452,108.8
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	3,088,501.6	3,581,580.8
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,155.7	192,475.1
2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,798,857.7	4,529,638.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны нэр, төрөл	5. Өмнөх он	6. Тайлант он
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,888,077.6	2,725,918.1
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,178,351.2	1,257,401.6
1.1.1.03.1 Орлогын албан татвар	395,848.3	400,490.5
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	395,848.3	400,490.5
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	67,228.2	84,627.6
1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	715,274.7	772,283.5
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	840,936.5	1,468,516.5
1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	147,266.8
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	868,790.0	-
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,782,179.7	1,835,287.1
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,782,179.7	1,835,287.1
1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,613,569.5	1,731,767.5
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	578,735.2	748,687.3
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,876.2	93,193.2
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,842.9	149,037.5
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	79,894.1	65,774.9
1.1.2.01.1.05 Нормативт зардал	-	19,821.8
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	124,176.2	24,098.8
1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	28,516.0	29,876.0
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,482.7	111,197.0
1.1.2.01.1.0 Бараа үйлчилгээний бусад зардал	589,046.2	490,081.0
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,610.2	103,519.5
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,105,898.0	890,631.0
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	348,410.0	410,232.5
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(348,410.0)	(410,232.5)
1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	757,487.9	480,398.5

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/ өмч
1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,991,459.0	2,991,459.0
1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(3,180.8)	(3,180.8)
1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,988,278.2	2,988,278.2
1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	757,487.9	757,487.9
1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,745,766.1	3,745,766.1
1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,745,766.1	3,745,766.1
1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,680.6	12,680.6
1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,758,446.8	3,758,446.8
1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(12,680.6)	(12,680.6)
1.7 Тайлант үеийн үр дүн	480,398.5	480,398.5
1 2025 оны 12-р сарын 31-наарх	4,226,164.7	4,226,164.7

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,393,418.1	2,412,313.0
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,178,351.2	1,257,401.6
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	395,848.3	400,490.5
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	67,228.2	84,627.6
1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	715,274.7	772,283.5
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,000.7	30,154.4
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	702,274.1	701,965.9
1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	40,163.2
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	346,276.9	1,154,911.4
1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	346,276.9	293,781.5
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	152,454.9
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	708,675.0
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,461,558.3	1,512,235.0
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,461,558.3	1,512,235.0
1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,292,948.1	1,380,213.4
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	578,411.0	748,964.2
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,876.2	93,193.2
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,467.9	152,294.6
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	54,185.6	48,478.6
1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,100.0	-
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	124,176.2	23,588.8
1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	28,516.0	21,920.0
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,482.7	109,997.0
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	293,732.5	181,777.0
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	168,610.2	132,021.6
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	931,859.8	900,077.9
1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,196,804.4	869,963.4
1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,196,804.4	869,963.4
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	1,196,804.4	869,963.4
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,196,804.4)	(869,963.4)

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

1.1	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(264,944.6)	30,114.6
1.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,237,736.7	972,792.1
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	972,792.1	1,002,906.7

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,960,824.0	2,259,858.1
Татварын орлого	2,119,565.0	1,257,401.6
Татварын бус орлого	1,841,259.0	1,002,456.5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,960,824.0	2,224,029.7
УРСГАЛ ЗАРДАЛ	2,256,632.2	1,357,656.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,911,451.5	1,260,245.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	830,103.6	748,964.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,500.8	93,193.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	180,019.5	143,870.8
Хангамж, бараа материалын зардал	76,838.8	43,965.2
Нормативт зардал	900.0	-
Эд хогшил, урсгал засварын зардал	39,117.4	23,588.8
Томилолт, зочны зардал	29,400.0	21,920.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	127,264.0	60,879.6
Бараа үйлчилгээний бусад зардал	522,307.4	123,863.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	345,180.7	97,411.3
Бусад урсгал шилжүүлэг	345,180.7	97,411.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,580,771.8	866,373.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ	123,420.0	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	965,041.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000,869.6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	152,454.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,454.9
122	Тусламжийн орлого	152,454.9
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117,844.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,844.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	117,844.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,423.8
2104	Хангамж, бараа материалын зардал	5,008.3
2106	Эд хогшил, урсгал засварын зарда	3,095.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,117.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,200.0
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(34,610.4)

## 3. Аудитын илрүүлэлт

### 3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар нийт 893,273.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 885,557.8 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, 7,716.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

#### 3.1 Албан шаардлага

- Төсвийн хөрөнгөөр **5,220.0** мянган төгрөгийн туршлага судлах, сургалт авах үйлчилгээг жуулчны баазад зохион байгуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан . Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн

захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих), 16.5.5-д (батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д (сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх) заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Эвлэрлийн гэрээний хугацаанд иргэн О.Бямбасүрэнгийн **18,174.4** мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ зохион байгуулаагүй. Энэ нь Энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74<sup>1</sup>.8-д (Эвлэрлийн гэрээг баталгаажуулсан шүүгчийн захирамж энэ хуулийн 75 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. Энэ захирамжийг талууд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэрийн нэг адил албадан гүйцэтгэнэ) эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.-д (Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй) Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх) заасныг, мөн оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Аудитаар нийт татварын орлогын батлагдсан төлөвлөгөөнөөс **862,163.4** мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т (Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ), 41.2.1-т (Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх), Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д (нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах)

*Шийдвэрлэсэн нь: Аудитаар илрүүлсэн зөрчилд таслан зогсоох, давтан гаргахгүй 3 хугацаатай албан шаардлага хүргүүлээ.*

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

*Илрүүлэлт:* Санхүүгийн тайлангаарх **7,716.0** мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг барагдуулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 (төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх), 16 дугаар зүйлийн 16.5.2-т (батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих) заасныг мөн оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж: Өглөгийн үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах;*

*Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.*

### 5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	<b>НИЙТ</b>	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 216,384.1 мянган төгрөгийн алдаа, 922,366.0 мянган төгрөгийн зөрчил нийт 1,138,750.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнээс 8,820.0 мянган төгрөгийн зөрчлийг нөхөн төлүүлэхээр 1 төлбөрийн акт тогтоож, 885,557.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 27,988.2 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитаар илрүүлсэн зөрчлийн 81 хувийг залруулагдаагүй, 19 хувийг залруулсан алдаа эзэлж байна. Нийт 922,366.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 19,792.2 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал учраас дүгнэлтэд нөлөөлөхгүй, 902,573.8 мянган төгрөгийн зөрчил нь санхүүгийн асуудал байна. Аудитын дүгнэлтэд нөлөөлөх санхүүгийн асуудал нь тооцсон материаллаг түвшингээс 33.1 дахин их тул нэгтгэсэн санхүүгийн тайланд “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	10,000.0	1	10,000.0			1	10,000.0				
ОНХС	2	206,384.1	1	18,000.0	1	188,384.1	2	206,384.1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>216,384.1</b>	<b>2</b>	<b>12,683.6</b>	<b>1</b>	<b>188,384.1</b>	<b>3</b>	<b>216,384.1</b>	-	-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	1	5,700.0					1	5,700.0				
ХХС	1	8,820.0	1	8,820.0								
БХС	1	7,716.0					1	7,716.0				
МХС	1	18,174.4			1	18,174.4						
Засаг дарга	1	862,163.4			1	862,163.4						
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>902,573.8</b>	<b>1</b>	<b>8,820.0</b>	<b>2</b>	<b>880,337.8</b>	<b>2</b>	<b>13,416.0</b>		-	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ИТХ	1	14,572.2					1	14,572.2				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
БХС	1	5,220.0			1	5,220.0		-				
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>19,792.2</b>			<b>1</b>	<b>5,220.0</b>	<b>1</b>	<b>14,572.2</b>				